



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 118

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох,
тендер хүчингүй болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.4.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 03 дугаар дүгнэлтийн дагуу Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, Есөнзүйл сумын сум дундын эмнэлэг, сумдын Эрүүл мэндийн төвүүдэд 2020 онд хэрэглэгдэх эм эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн 1 дүгээр багц Ерөнхий мэдээгүйжүүлэх бэлдмэлд 8914200 (найман сая есөн зуун арван дөрвөн мянга хоёр зуу) төгрөгөөр Өвөрхангай- Эм хангамж ХХК-иар, 2 дугаар багц Өвдөлт намдаах, халуун бууруулах, үрэвслийн эсрэг эмд 13568200 (арван гурван сая таван зуун жаран найман мянга хоёр зуу) төгрөгөөр Ази фарма ХХК-иар, 3 дугаар багц Сэтгэл засал, уналт, таталтын эсрэг эмнүүд 20552894 (хорин сая таван зуун тавин хоёр мянга найман зуун ерэн дөрөв) төгрөгөөр Өвөрхангай- Эм хангамж ХХК-иар, 5 дугаар багц Харшлын эсрэг хордлого тайлах эм 7010400 (долоон сая арван мянга дөрвөн зуу) төгрөгөөр Монфа трейд ХХК-иар, 7 дугаар багц Халдварын эсрэг эм, бэлдмэлүүд 19234350 (арван есөн сая хоёр зуун гучин дөрвөн мянга гурван зуун тавь) төгрөгөөр Нахиа импекс ХХК-иар, , 8 дугаар багц Зүрх судасны үйл ажиллагааг сайжруулах бэлдмэлүүд 19886660 (арван есөн сая найман зуун наян гургаан мянга зургаан зуун жар) төгрөгөөр Азифарма ХХК-иар, 9 дүгээр багц Цусны даралтанд нөлөөлөх, шээс хөөх эм бэлдмэлүүд 7497140 (долоон сая дөрвөн зуун ерэн долоон мянга нэг зуун дөч) төгрөгөөр Азифарма ХХК-иар, 10 дугаар багц Арьсны өвчнийг эмчлэх бэлдмэлүүд 1167400 (нэг сая нэг зуун жаран долоон мянга дөрвөн зуу) төгрөгөөр Монфа трейд ХХК-иар, 11 дүгээр багц Хоол боловсруулах үйл ажиллагаанд нөлөөлөх эм, бэлдмэлүүд 13700400 (арван гурван сая долоон зуун мянга дөрвөн зуу) төгрөгөөр Монфа трейд ХХК-иар, 12 дугаар багц Дуслаар хэрэглэх бэлдмэлүүд (Монголд үйлдвэрлэсэн) 41197880 (дөчин нэгэн сая нэг зуун ерэн долоон мянга найман зуун наян) төгрөгөөр Энхийн шүүдэр ХХК-иар, 13 дугаар багц Дуслаар хэрэглэх амин дэм 3605840 (гурван сая зургаан зуун таван мянга найман зуун дөч) төгрөгөөр Азифарма ХХК-иар, 14 дүгээр багц Дотоодод үйлдвэрлэсэн эм 4451250 (дөрвөн сая дөрвөн зуун тавин нэгэн мянга хоёр зуун тавь) төгрөгөөр Нахиа импекс ХХК-иар, 17 дугаар багц Нөхөн үржихүйн эм бэлдмэлүүд 5345400 (таван сая гурван зуун дөчин таван мянга дөрвөн зуу) төгрөгөөр Азифарма ХХК-иар, 18 дугаар багц Эмнэлгийн багаж, хэрэгсэл 29893000 (хорин есөн сая найман зуун ерэн гурван мянга) төгрөгөөр Мөнхийн тун ХХК-иар, 19 дүгээр багц Зүү тариур

011100067

(Дотоодод үйлдвэрлэсэн) 50663095 (тавин сая зургаан зуун жаран гурван мянга ерэн тав) төгрөгөөр Мөнхийн тун ХХК-иар, 20 дугаар багц Дотоодод үйлдвэрлэгдсэн тарилга 9987800 (есөн сая есөн зуун наян долоон мянга найман зуу) төгрөгөөр Нахиа импекс ХХК-иар, 21 дугаар багц Ариутгал халдваргүйтлийн бодисууд (Монголд үйлдвэрлэсэн) 6158960 (зургаан сая нэг зуун тавин найман мянга есөн зуун жар) төгрөгөөр Вестмед ХХК-иар, 22 дугаар багц Цэвэрлэгээний бодис 7053500 (долоон сая тавин гурван мянга таван зуу) төгрөгөөр Мөнхийн тун ХХК-иар, 24 дүгээр багц Резинэн эдлэл, ороох боох материал 15334100 (арван таван сая гурван зуун гучин дөрвөн мянга нэг зуу) төгрөгөөр Тавин Ус ХХК-иар, 25 дугаар багц Лабораторийн урвалж бодисууд, оношлуур 52527690 (тавин хоёр сая таван зуун хорин долоон мянга зургаан зуун ер) төгрөгөөр Монфа трейд ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв)-т даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын нягтлан бодогч (Б.Валя)-д зөвшөөрсүгэй.

4. Шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй 4 дүгээр багц Уламжлалт анагаах ухааны эм (Монголд үйлдвэрлэсэн), 15 дугаар багц Амин дэм, эрдэс бодисууд, 6 дугаар багц Амьсгалын замын үйл ажиллагаанд нөлөөлөх эм, 16 дугаар багц Дотоодод үйлдвэрлэгдсэн антибиотууд, 23 дугаар багц Дотоодод үйлдвэрлэгдсэн резинэн эдлэл, ороох боох материалын багцуудыг хүчингүй болгосугай.

5. Дээрх хүчингүй болсон багцуудыг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар дахин зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНБОЛД